

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ,
НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ӨВА-2022/31-7-ШТА-ГА

Арвайхээр хот
2022 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор **О.Батжаргал**

Утас: 70323253, цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер **Д.Гансүх**,

Утас: 70323833, цахим хаяг: Gansukhd@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Шийлэгмаа**,


Утас: 70323833, цахим хаяг: Shiilegmaas@audit.gov.mn

Аудитор: **Б.Авидцэрэн**,

Утас: 70323833, цахим хаяг: Avidtserenb@audit.gov.mn

Аудитор: **П.Норпил**,

Утас: 70323833, цахим хаяг: Norpilp@audit.gov.mn



АГУУЛГА

АГУУЛГА.....	1
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	5
1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж байна	7
1.1. Аймаг хөгжүүлэх 5-н жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлж байна	7
1.1.1. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, эх үүсвэрийг бодитой тооцож төлөвлөөгүй байна.....	7
1.1.2. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тогтоосон хугацаанд гаргаж дүгнэсэн байна	8
1.1.3. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийгдсэн хяналт, шинжилгээ үнэлгээний дүн 93.7 хувьтай байна	8
1.1.4. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр үүрэг даалгавар өгөгдөөгүй байна	8
1.2. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэж ажилласан байна	8
1.2.1. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, эх үүсвэрийг бодитой тооцож төлөвлөх боломжгүй байна.....	8
1.2.2. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн уялдааг сайжруулах хэрэгцээтэй байна	8
1.2.3. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тогтоосон хугацаанд гаргаж хүргүүлж байна	9
1.2.4. Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийгджээ	9
1.2.5. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дүгнээд хэрэгжээгүй болон дутуу хэрэгжсэн ажлуудыг сайжруулах чиглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна	9
2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хууль тогтоомжид заасны дагуу төлөвлөж хуваарилаагүй байна	10
2.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос батлагдсан төлөвлөгөөний хүрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуульд заасан хувь хэмжээгээр зардал баталж байгаа боловч төлөвлөөгүй орлогоос хөрөнгө хуваарилахгүй байна	10
2.1.1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөөгүй байна.....	10
2.1.2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн нийт орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зориулж төлөвлөхгүй байна	10
2.1.3. Газрын нөөц ашигласны төлбөрийн орлого орон нутгийн төсөвт төвлөрдөггүй тул зардал төлөвлөөгүй байна	11
2.1.4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөөгүй байна.....	11
2.1.5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна	12
2.2. Аймгийн Засаг дарга нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг ИТХ-аар хэлэлцүүлж батлуулахгүй байна	12
2.2.1. Аймгийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан ч зардлыг хууль, журмын дагуу төлөвлөөгүй, сүүлийн онуудад ИТХ-д өргөн мэдүүлж батлуулаагүй байна	12
2.2.2. Аймгийн Засаг дарга нь байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний талаар ИТХ- аар шийдвэр гаргуулаагүй байна.....	14



3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийн зарим хэсгийг зориулалт бусаар зарцуулсан байна	14
3.1. Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна	14
3.1.1. Арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна	14
3.1.2. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан байна	15
3.1.3. Гүйцэтгэчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна	15
3.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн ч зарим гэрээний биелэлт хангалтгүй байна	15
3.2.1. Ихэнх арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон ч бий болгосон зарим хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна	15
3.2.2. Ойжуулалтын ажил үр дүнтэй байгаа ч зарим арга хэмжээний гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй байна	15
3.2.3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр зарцуулаагүй байна	16
4. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна	17
4.1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтэд тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна	17
4.1.1. Арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, баталгаажуулсан байна	17
4.1.2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалтад тавих ТЕЗ-ийн дотоод хяналт үр нөлөө багатай байна	17
4.2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд харьяа дээд шатны байгууллагаас хийгдэх хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна	17
4.2.1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тавих төрийн байгууллагуудын хяналт хангалттай байна	17
4.2.2. Арга хэмжээний зарцуулалтад тавих төрийн байгууллагуудын хяналтыг сайжруулах шаардлагатай байна	17
Дүгнэлт	18
Зөвлөмж	20



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БХНС	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАГ	Төрийн аудитын газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТА	Шууд тайлагнах аудит
УИХ	Улсын Их Хурал
ӨВА	Өвөрхангай аймаг



Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Амьтны төлбөрийн орлого, арга хэмжээний төлөвлөгөө	11
Хүснэгт 2	Ойн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, зардлын төлөвлөгөө	12
Хүснэгт 3	Ус, рашааны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, зардлын төлөвлөлт	13
Хүснэгт 4	Журам зөрчиж хэрэгжүүлсэн арга хэмжээ	14
Хүснэгт 5	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, зардал	14

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Бат-Өлзий суманд хийгдсэн ойжуулалт, хашаажуулалд	17
Зураг 2	Сум дундын ойн анги, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын хүлэмжийн үрсэлгээ	17

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1		

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1		



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан аудитын төлөвлөгөө, аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан ӨБА-2022/31-7-ШТА-ГА кодтой төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэлээ.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд төсвөөс олгосон хөрөнгийг хууль тогтоомж, журам зааврын дагуу үр дүнтэй зарцуулж буй эсэхэд гүйцэтгэлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтан, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ.

Аудитын зорилт

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэх
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хууль тогтоомжид заасны дагуу төлөвлөж хуваарилсан эсэх
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд тавих хяналтыг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамрах хүрээ

Аудитыг 2020-2022 оны эхний хагас жилийн аймгийн БОАЖГ, түүний харьяа Сум дундын ойн анги, аймаг сумдын ИТХ, Засаг дарга, Татварын хэлтэс, ОНӨГ, холбогдох аж ахуйн нэгжүүдийг хамруулан тэдгээрийн ажлын тайлан, статистик мэдээ, судалгааны материалд тулгуурлан хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “ТАБ-аас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, санал асуулга, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитад ашиглах хууль тогтоомж,

Дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.



**шалгуур
үзүүлэлтүүд**

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Татварын ерөнхий хууль
- Ойн тухай хууль
- Усны тухай хууль
- Байгалийн ургамлын тухай хууль
- Ан амьтны тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоол, 2022 оны 02 дугаар тогтоол “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах тайлагнах журам/
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд
- Аймгийн ИТХ-ын тогтоолууд
- Аймгийн Засаг даргын захирамжууд

**Аудит хийх
бүрэлдэхүүн**

Аудитыг Өвөрхангай аймаг дах Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор О.Батжаргал удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Д.Гансүх хэрэгжүүлж, ахлах аудитор С.Шийлэгмаа, аудитор Б.Авидцэрэн, П.Норпил нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 9 дугаар сарын 10-ний өдрөөс эхлүүлж, тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлээ.


Үндсэн мэдээлэл:

Өвөрхангай аймгийн Засаг дарга Байгаль орчин, аялал жуулчлалын хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15.1.2, 15.1.7, 16.2, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх хэсгийг үндэслэн БОАЖЯ-ны сайд, Засаг даргын хамтран ажиллах гэрээг жил бүр байгуулж байна. Энэ гэрээнд орон нутгийн төсвөөс 2020 онд 197.4 сая, 2021 онд 460.4 сая, 2022 онд 562.0 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулахаар тусгажээ.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг нийт дүнгээр 2020 оны төсвийг Аймгийн ИТХ-ын 2019 оны 12/09 дүгээр тогтоолоор 197.4 сая, 2021 оны төсвийг 2020 оны 03/07 дугаар тогтоолоор 460.4 сая, 2022 оны төсвийг 2021 оны 07/08 дугаар тогтоолоор 562.0 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Энэ батлагдсан төсвийг аймгийн ИТХТ-ийн 2020 оны 20 дугаар тогтоолоор “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг үндэслэн тухайн онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 9 арга хэмжээнд 147.4 сая төгрөг, хоёрдугаар хавсралтаар 50.0 сая төгрөгийн автомашин худалдан авахад зарцуулахаар баталжээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/24, 2022 оны А/42 дугаар захирамжаар “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Засгийн газрын 2014 оны 43, 2022 оны 02 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийг үндэслэн 2021 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 15 арга хэмжээнд 460.4 сая, 2022 онд 14 арга хэмжээнд 562.0 сая төгрөг баталсан байна.



Аймгийн ИТХ-аас Нийтийн сонсголын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтын дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх сангийн 2020 оны зарцуулалтад 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр хийх төсвийн хяналтын сонсголд зориулан дүгнэлт гаргуулах хүсэлтийг ирүүлсэн байна.

Энэхүү хүсэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр МУЕА-т хүргүүлснээр 10 дугаар сарын 12-ны өдөр дүгнэлт гаргах чиглэл ирсний дагуу “2020 оны Байгаль хамгаалах сангийн зарцуулалтад дүгнэлт гаргах” аудитыг 12 хоногийн дотор хийж гүйцэтгэжээ.

Тус аудитаар байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас БОАЖГ-т автомашин 47.9 сая төгрөг, байгаль орчны байцаагчид мотоцикл 1.9 сая төгрөгөөр худалдан авсан.

Өв Гэрэл зурагчдын холбоо ТББ-д байгаль орчноо хамгаалах танин мэдэхүйн боловсролыг дэмжих чиглэлээр гэрэл зургийн цомог хэвлүүлэхэд 65.0 сая төгрөг, ой бүхий нутаг дэвсгэрээс хушны самар бэлтгэж ашиглахтай холбогдуулан хяналт шалгалт явуулахад 2.7 сая төгрөг шилжүүлсэн зэрэг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсан.

“Жем Хужирт” ХХК нь аймгийн ИТХ-ын 2018 оны 09/11 дүгээр тогтоолын дагуу Ус ашиглах гэрээг байгуулаагүй, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 20.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрсэн байна.

Энэхүү нийт 117.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлжээ.

Биелэлтийг аймгийн БОАЖГ-ын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 87 дугаар албан бичгээр аудитаар илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллаж байгаа, “Жем Хужирт” ХХК-тай ус ашиглах гэрээг байгуулж ус, рашааны нөөц ашигласны төлбөр 20.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн талаар хариуг ирүүлсэн байна.

Аудитаар 7 зөвлөмж, 274.1 сая төгрөгийн 3 албан шаардлага өгч, үр өгөөжийг тооцон холбогдох байгууллагуудад хүргүүлж байна.

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна

1.1. Аймаг хөгжүүлэх 5-н жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлж байна

1.1.1. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, эх үүсвэрийг бодитой тооцож төлөвлөөгүй байна

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 бодлогын баримт бичиг, Өвөрхангай аймгийг 2014-2024 онд хөгжүүлэх эдийн засгийн урт хугацааны бодлого, стратегид хүрэхэд эн түрүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай дунд хугацааны зорилго, зорилт, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, мөн Алсын хараа-2050 хөгжлийн бодлогын баримт бичиг, Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичигт Байгалийн нөөц ашиглалт, нөхөн сэргээлтийн талаар 5 зорилт тусгагдсан боловч зорилтод арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, эх үүсвэрийг бодитой тооцож төлөвлөөгүй байна.



1.1.2. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тогтоосон хугацаанд гаргаж дүгнэсэн байна

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Ногоон хөгжил, аялал жуулчлал” бүлэгт 3 зорилт, 7 арга хэмжээг дэвшүүлэн ажиллаж хэрэгжилтийг жил бүр дүгнэсэн байна.

1.1.3. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийгдсэн хяналт, шинжилгээ үнэлгээний дүн 93.7 хувьтай байна

Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд “Ногоон хөгжил, байгаль орчин” бодлогын хүрээнд 4 чиглэл, 4 зорилт, 17 арга хэмжээ тусган хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2021 оны хэрэгжилтийн дундаж 95.0 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дүгнэсэн байна.

Мөн аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Ногоон хөгжил, аялал жуулчлал” бүлэгт 3 зорилт, 7 арга хэмжээг нэгтгэн дүгнэж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хэлэлцэж, хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний 2021 оны хэрэгжилт үр дүнг 92.4 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2021 онд хийгдсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний дүн 93.7 хувьтай байна.

1.1.4. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр үүрэг даалгавар өгөгдөөгүй байна

Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд дэвшүүлсэн “Ногоон хөгжил, байгаль орчин” бодлого, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Ногоон хөгжил, аялал жуулчлал” бүлэгт ажлыг сайжруулах чиглэлээр үүрэг даалгавар өгөгдөөгүй байна.

1.2. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэж ажилласан байна


1.2.1. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, эх үүсвэрийг бодитой тооцож төлөвлөх боломжгүй байна

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, үндсэн чиглэлийн биелэлт, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг салбарын сайдтай байгуулсан гэрээний хүрээнд тайлагнадаг байна. Чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэлийг зорилт бүрийн дагуу тайлагнаж дүгнэлтийг бүлгийн хүрээнд үнэлсэн байна.

Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг төсвийн төсөл боловсруулахад тусгаагүй, төсвийг Сангийн яамнаас баталж өгдөггүй байна. Эдгээр хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ тухайн онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилтай уялдуулан гүйцэтгэж байна.

1.2.2. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн уялдааг сайжруулах шаардлагатай байна

Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл болон Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн ажлууд үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн ерөнхий бодлого чиглэлтэй нийцэж байна. Үндэсний болон дэд хөтөлбөр, бодлогод хяналтын тогтолцоо, олон улсын харилцаа, салбар бүрд шинжлэх ухаан, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх талаар зохих хэмжээгээр тусгаж оруулсан байна.



Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээг товч, тодорхой байдлаар төлөвлөжээ. Харин аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд зарим цар хүрээ багатай, хэрэгжүүлэх ажлын хүрэх үр дүн нь тодорхойгүй арга хэмжээг төлөвлөжээ.

Үндсэн чиглэл, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт төлөвлөсөн ажлууд нь хамрах хүрээ, ажлын нарийвчилсан задаргаа багатай, хүрэх үр дүн тодорхойгүй зэрэг сул талуудтай байна. Үндэсний хэмжээнд мөрдөгдөж байсан зарим хөтөлбөр, бодлогыг хүчингүй болгосон, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудад шинэчлэлт хийгдээгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 89 дүгээр тогтоолоор байгаль орчинд хамааралтай дараах хөтөлбөрүүдийг хүчингүй болгожээ. Үүнд:

- ⇒ Төрөөс экологийн талаар баримтлах бодлого / УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоолоор батлагдаж байсан /
- ⇒ Төрөөс ойн талаар баримтлах бодлого / УИХ-ын 2015 оны 49 дүгээр тогтоолоор батлагдаж байсан /
- ⇒ “Ус” үндэсний хөтөлбөр батлах тухай / УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоолоор батлагдаж байсан /
- ⇒ Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр батлах тухай / УИХ-ын 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдаж байсан/

Уг хөтөлбөрүүдийн хамрах хүрээний асуудлууд нь байгаль орчны асуудалтай ихээхэн хамааралтай бөгөөд дахин шинэчлэгдсэн хувилбараар хөтөлбөрүүд батлагдаагүй байна.

1.2.3. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тогтоосон хугацаанд гарган хүргүүлж байна


УИХ, Засгийн газрын тогтоолоор батлагдсан Үндэсний хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас батлан гаргасан хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг БОАЖЯ, аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс, газруудад заасан хугацаанд тайлагнадаг байна. УИХ, Засгийн газрын тогтоолоор батлагдсан 6 үндэсний хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилт тус аймагт 81.7 хувь, дэд хөтөлбөрийн биелэлт 86.5 хувь, биелэлтийн дундаж 84.1 хувьтай үнэлэгджээ. Аудитын явцад тодруулахад УИХ-ын 89 дүгээр тогтоолтой холбоотойгоор үндэсний болон дэд хөтөлбөрийн биелэлтийг 2021 оноос түдгэлзүүлсэн байна. Өмнөх онуудад гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлж байжээ.

1.2.4. Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийгджээ

Аймгийн Засаг даргын салбарын сайдтай байгуулсан байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээгээр 2021 онд 90.6 хувьтайгаар үнэлэгджээ. Нийт 51 арга хэмжээ хэрэгжүүлснээс 34 нь үр дүнтэй, 14 нь тодорхой үр дүнд хүрсэн, 1 нь үр дүнгүй гэж үнэлэгдсэн бөгөөд 2 арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байжээ.

1.2.5. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээгээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна

БОАЖ-ын сайдын аймгийн Засаг даргатай байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2020 онд хамтран ажилласан гэрээний үүргийг тус яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас дүгнэсэн байна. Гэрээний үүргийн биелэлтийн үнэлгээгээр тус аймаг 75.2 хувьтай үнэлэгдэж байжээ. Хяналтаар илэрсэн дутагдалтай асуудлуудад 7 төрлийн зөвлөмж, салбар яамны сайдтай байгуулах гэрээнд тусгах 10 зорилтыг дэлгэрэнгүй зааж өгсөн байна.



Харин 2021 онд сайдтай хамтран ажиллах гэрээг өмнөх онд өгсөн зөвлөмж, аргачлалын дагуу байгуулж чадаагүй байна. Зорилт, арга хэмжээг оновчтой тодорхойлоогүй, арга хэмжээнүүдийг агуулгын хувьд давхцуулсан, өмнөх оны зөвлөмжөөр өгсөн сургалт зохион байгуулах, мэдээллийн санд мэдээ оруулах зэрэг хууль тогтоомжийн дагуу хийгдэх ажлуудыг тусгасан байна.

2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хууль тогтоомжид заасны дагуу төлөвлөж хуваарилаагүй байна

2.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос батлагдсан төлөвлөгөөний хүрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуульд заасан хувь хэмжээгээр зардал баталж байгаа боловч төлөвлөгөөнөөс давсан орлогоос хөрөнгө хуваарилахгүй байна

2.1.1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөөгүй байна

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 15 хувиар тооцож зардлын төлөвлөлт хийх ёстой ч зардал төлөвлөдөггүй байна.

Тус аймгийн байгалийн ашигт ургамлын тархац, нөөцийн судалгааг 2021 онд хийлгэж, нэн ховор, ховор, эмийн, ашиглалтад өртөмтгий ургамлын тархац, ашиглалтын нөөцийг тогтоолгосон боловч эдгээр ургамал нь байнгын ашиглалтад нийцэхүйц нөөцтэй бус байдгаас шалтгаалан ашиглах хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж байдаггүй тул байгалийн ашигт ургамлаас орох орлого, тэдгээрийг нөхөн сэргээх зардлыг төлөвлөхгүй байна.

2.1.2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн нийт орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зориулж төлөвлөхгүй байна

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1.2-т ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 50-иас доошгүй хувиар тооцож байгаль орчныг хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх зардлыг төлөвлөхөөр тусгасан байдаг.

Ан амьтны нөөц нөөц ашигласны төлбөрт 2019 онд 607.2 сая, 2020 онд 179.3 сая, 2021 онд 2,145.4 сая төгрөгийн орлого тус тус оржээ. Энэ төлбөрийн орлого, түүнээс байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төлөвлөсөн хөрөнгө дараах байдалтай байна.

Хүснэгт 1 / Амьтны төлбөрийн орлого, арга хэмжээний төлөвлөгөө /

Он	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого		БХНС арга хэмжээнд зориулбал зохих		БХНС арга хэмжээнд төлөвлөсөн зардал	Төлөвлөсөн зардлын	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хуулийн 18.1-д заасан хувь	Мөнгөн дүн		Батлагдсан төлөвлөгөөнд эзлэх хувь	Тухайн оны гүйцэтгэлд эзлэх хувь
2020	178.00	179.3	50.0	89.65	89.0	50.0	49.6
2021	256.9	2145.4	50.0	1072.7	0	0.0	0.0

Хүснэгтээс үзвэл 2020 онд батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуулийн хувиар тооцож байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн боловч 2021 онд зардал төлөвлөөгүй байна. Энэ нь тухайн онд төлбөрийн орлогыг төлөвлөөгүйгээс гүйцэтгэлээр орсон орлогыг төлөвлөгөөнөөс давсан орлого гэж үзэж, түүнээс байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардал тооцоогүйтэй холбоотой.



Аймгийн хэмжээнд ан амьтны нөөц ашиглалтыг төлөвлөхдөө аргаль, янгир, халиун бугын ангаас орох орлогоор тооцдог. Аймгийн БОАЖГ-аас тухайн онд агнуулах боломжит ангийн тоо толгойн саналыг БОАЖЯ-нд гаргаж өгдөг ба энэ тоо нь сайдын тушаалаар батлагдахдаа өөрчлөгдөж ирдэг байна.

Харин шонхор шувуу бариулах үйл ажиллагаа нь уг шувууны байршил нь хоол тэжээлээсээ үүдэн өөрчлөгддөг хөдөлгөөнт ан байдгаас шалтгаалж төлөвлөх боломжгүй байдаг байна. 2021 оноос бариулсан шонхор тутмаас орох орлого нь Засгийн газрын 2006 оны 171 дүгээр тогтоолд заасан хэмжээгээр бүрэн төлөгддөг болсонтой холбоотойгоор орон нутагт орох ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл үлэмж нэмэгджээ. Эдгээр орлогыг нэгэнт төлөвлөөгүй байдаг тул төлөвлөгөөнөөс давсан орлогоор тооцож, үүнээс байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардал огт тооцдоггүй байна.

2.1.3. Газрын нөөц ашигласны төлбөрийн орлого орон нутгийн төсөвт төвлөрдөггүй тул зардал төлөвлөөгүй байна

Газрын нөөц ашигласны төлбөр нь орон нутгийн төсөвт ордоггүй тул уг төлбөрийн орлогоос зарцуулах хөрөнгийг төлөвлөөгүй байна.

2.1.4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөөгүй байна

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д зааснаар ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 85.0 хувиар тооцож байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд төлөвлөх ёстой.

Тус аймгийн хувьд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө болон гүйцэтгэл, уг орлогоос зардал төлөвлөсөн байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2 / Ойн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, зардлын төлөвлөлт /


Он	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого		БХНС арга хэмжээнд зориулбал зохих		БХНС арга хэмжээнд төлөвлөсөн зардал	Төлөвлөсөн зардлын	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хуулийн 18.1-д заасан хувь	Мөнгөн дүн /гүйцэтгэлээр/		батлагдсан төлөвлөгөөнд эзлэх хувь	тухайн оны гүйцэтгэлд эзлэх хувь
2020	163.0	350.0	85.0	297.5	138.6	85.0	39.6
2021	130.0	457.6	85.0	389.0	110.5	85.0	24.1

Хүснэгтээс харахад, ойн нөөц ашигласны төлбөрийн гүйцэтгэлээс тооцвол зохих дүнгээс 45.4-60.9 хувиар бага зардлыг байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардалд төлөвлөж байна. Энэ нь төлбөрийн орлогыг хэт багаар төлөвлөсөнтэй холбоотой байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т: “Ойн дагалт баялгийн нөөц самар, мөөг, давирхай, шилмүүс, мөчир, үр, хусны шүүсэнд төлбөр ногдуулна” гэж заасан боловч уг орлого болон түүнээс байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардалд зарцуулах хөрөнгийг төлөвлөдөггүй байна.

Хуш модны самар түүх бэлтгэх төлбөрөөр тус аймгийн 4-5 суманд зарим жилд тодорхой хэмжээний орлого ордог боловч тухайн жилийн ургалтын байдал таамаглашгүй байдгаас шалтгаалж энэ орлогыг төлөвлөх боломжгүй байдаг байна.

Иймээс хэрэв орлого олсон бол энэ нь төлөвлөгөөнөөс давсан орлогод тооцогдож, түүнээс байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулахгүй явж иржээ.



2.1.5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д зааснаар ус, рашаан ашигласны төлбөрийн орлогоос 35.0 хувиар тооцож байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд төлөвлөх ёстой.

Тус аймгийн хувьд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө болон гүйцэтгэл, уг орлогоос зардал төлөвлөсөн байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3 / Ус, рашааны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, зардлын төлөвлөлт /

Он	Ус, рашаан ашигласны төлбөрийн орлого		БХНС арга хэмжээнд зориулбал зохих		БХНС арга хэмжээнд төлөвлөсөн зардал	Төлөвлөсөн зардлын	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хуулийн 18.1-д заасан хувь	Мөнгөн дүн		Батлагдсан төлөвлөгөөнд эзлэх хувь	Тухайн оны гүйцэтгэлд эзлэх хувь
2020	345.0	339.6	35.0	118.9	120.7	35.0	35.5
2021	400.0	313.5	35.0	109.7	140.0	35.0	44.7

Ус, рашаан ашигласны төлбөрөөс байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуулийн хувиар тооцож зардал төлөвлөж байгаа боловч 2021 онд төлбөрийн орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

2.2. Аймгийн Засаг дарга нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг ИТХ-аар хэлэлцүүлж батлуулахгүй байна

2.2.1. Аймгийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан ч зардлыг хууль, журмын дагуу төлөвлөөгүй, сүүлийн онуудад ИТХ-д өргөн мэдүүлж батлуулаагүй байна

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 2020 оны төсвийг Аймгийн ИТХ-ын 2019 оны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 12/09 тоот тогтоолоор баталсан бол хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт, тэдгээрт зарцуулах хөрөнгийн хуваарийг аймгийн ИТХТ-ийн 2020 оны 20 дугаар тогтоолоор баталсан байна.

Харин 2021, 2022 оны зардлын төсвийг аймгийн ИТХ-ын тогтоолоор дүнгээр нь баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ, тэдгээрт зарцуулах хөрөнгийн хэмжээг аймгийн Засаг даргын захирамжаар баталжээ. Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д: “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих”, 16.2-т: “Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах”, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т: “Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, сум, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална” гэж заасныг тус тус зөрчжээ.

Тухайн онуудад хэрэгжүүлэхээр баталсан арга хэмжээний төсвөөс 2020 онд 30.4 хувь, 2021 онд 12.4 хувь, 2022 онд 10.7 хувийг байгаль хамгаалах, нөхөн сэргээхээс бусад үйл ажиллагаанд зориулалт бусаар зарцуулахаар /төв суурин газарт мод тарих,

зүлэгжүүлэх, ногоон байгууламж байгуулах, тэдгээрийн арчилгаа, мандлын цэцгийн үрслэгээний зардлыг зориулалт бус гэж тооцоогүй/ баталсан байна. Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1: “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно” гэсэн заалт, Засгийн газрын 2014 оны 43, 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах” журмуудын “Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт” хэсгийн заалтуудыг тус тус зөрчсөн байна.


Хүснэгт 4 / Журам зөрчиж хэрэгжүүлсэн арга хэмжээ /

Он	Нийт батлагдсан зардал	Үүнээс зориулалт бус зардалд баталсан			Нийт батлагдсан төсөвт зориулалт бус зардлын эзлэх хувь
		Арга хэмжээний нэр	Зардлын дүн	Жилийн дүн	
2020	197.4	БОАЖГ-ын мэргэжилтэн, сумдын байгаль хамгаалагч, БОХУ байцаагч нарыг чадавхжуулах, хувцас, техник хэрэгслээр хангах, эрүүл мэндийн үзлэгт хамруулах	10.0	60.0	30.4
		БОАЖГ-ын автомашиныг шинэчлэх	50.0		
2021	460.4	Сум дундын Ойн анги, сумдын байгаль хамгаалагч нарыг өвлийн хувцас, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, ажлын байрны нөхцөлийг сайжруулах	10.0	56.9	12.4
		Аялал жуулчлалын эвент арга хэмжээ зохион байгуулах, "Ай Ти Эм" аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд оролцох, аялал жуулчлалын танилцуулга, гарын авлага бэлтгэх, сурталчлах	10.0		
		Орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний "Цахим аяллын хөтөч" аппликейшн нэвтрүүлэх	36.9		
2022	562.0	Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд төв суурин газрын нийтийн эзэмшлийн талбайд тарих модны тарьц, суулгац худалдан авч сумдад нийлүүлэх	60.0	60.0	10.7

Аймгийн хэмжээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн жилийн бодит орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зардал батлахдаа Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1.1-д заасан хувь, хэмжээг мөрдөөгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5 / Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, зардал /

д/д	Төлбөрийн орлогын нэр	Хувь хэмжээ	2020 он			2021 он		
			Орлого гүйцэтгэлээр	Зарцуулбал зохих хөрөнгө	Батлагдсан хөрөнгө	Орлого гүйцэтгэлээр	Зарцуулбал зохих хөрөнгө	Батлагдсан хөрөнгө
1	Ойн нөөц ашигласны төлбөр	85	350.0	297.5		457.6	389.0	
2	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	50	179.3	89.7		2,145.4	1,072.7	
3	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	35	339.6	118.9		313.5	109.7	
	Дүн		868.9	506.0	416.0	2,916.5	1,571.4	460.4
	Зөрүү				90.0			1,111.0



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс зардлыг тооцож байгаа боловч төлөвлөснөөс давж орсон орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд хөрөнгө хуваарилахгүй байна.

Засгийн газрын 2022 оны 02 тоот тогтоолын дагуу 2023 оны төлөвлөлтийг сум бүр цахимаар хийсэн байна.

2.2.2. Аймгийн Засаг дарга нь байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний талаар ИТХ-аар шийдвэр гаргуулахгүй байна.

Аймгийн Засаг дарга нь 2021 оноос байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний жагсаалт, тэдгээрт хуваарилсан хөрөнгийн хэмжээг аймгийн ИТХ-аар батлуулахгүй, зөвхөн өөрийн захирамжаар баталсан байна. Энэ нь эдгээр арга хэмжээг аймгийн иргэдийн төлөөлөгчдөөр хэлэлцүүлэхгүй, тусгасан арга хэмжээг батлахгүй байгааг харуулж байна.

Засаг даргын захирамжийн дагуу төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг аймгийн БОАЖГ хариуцан ажиллаж байна.

Цаашид Байгаль хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дахь заалт, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг мөрдөн ажиллаж, арга хэмжээ, тэдгээрт зарцуулах хөрөнгийг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж байх, уг шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах, байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлын төсвийг зориулалтын арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж байх талаар зөвлөмж, албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийн зарим хэсгийг зориулалт бусаар зарцуулсан байна

3.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна

3.1.1. Арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна


Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020 онд 97.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 арга хэмжээг БОАЖГ-т харьцуулалтын аргаар цахимаар, төлөвлөсөн хугацаанд нь зохион байгуулсан.

Мөн 20.0 сая төгрөгийн өртөгтэй, 2 багц бүхий “Булаг шанд, рашаан, голын эхийг хашиж хамгаалах материал нийлүүлэх” арга хэмжээний хугацааг төлөвлөснөөс 2 сараар хоцроож зарласан ч уг арга хэмжээг тайлант хугацаанд багтаан хэрэгжүүлж, хүлээлгэн өгчээ.

БОАЖГ нь 2021 онд 111.9 сая төгрөгийн өртөгтэй 4 арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар, харьцуулалтын аргаар төлөвлөсөн хугацаанд нь зохион байгуулсан байна.

Харин 2022 онд 349.6 сая төгрөгийн өртөгтэй 5 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймгийн БОАЖГ-т, 200.0 сая төгрөгийн 4 багц бүхий 1 төслийн худалдан авах ажиллагааг ОНӨГ-т, бүгдийг цахимаар, бүгдийг харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.

Эдгээрээс “Хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор хөрсөнд үл нэвчих эко ариун цэврийн байгууламж байршуулах” 38.0 сая төгрөгийн арга хэмжээний худалдан авах ажиллагаа нь тус байгууламжийн судалгаа удааширснаас шалтгаалж төлөвлөснөөс 4 сараар хоцорч зарлагдсан ба бусдыг төлөвлөсөн хугацаанд зарлаж, тайлант онд багтаж хэрэгжих боломжийг хангахуйцаар зохион байгуулжээ.



ОНӨГ-т зарласан 200.0 сая төгрөгийн сонгон шалгаруулалтын зөвхөн 1 багцад шаардлага хангасан төсөл ирснийг шалгаруулж, бусдыг БОАЖГ шууд гэрээ байгуулах замаар гүйцэтгүүлж байна.

3.1.2. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан байна

БОАЖГ болон ОНӨГ-т байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар 2020-2022 онд нийтдээ 13 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулсан байна.

3.1.3. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна

Аймгийн БОАЖГ-аас 2020 онд 117.4 сая төгрөгийн 3, 2021 онд 111.9 сая төгрөгийн 4, 2022 онд 349.6 сая төгрөгийн 5 арга хэмжээний гүйцэтгэгчийг tender.gov.mn цахим хуудсаар ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж шалгаруулсан ба 2021 онд 50.0 сая төгрөгийн өртөг бүхий 3 арга хэмжээний гэрээг хуульд нийцүүлэн шууд байгуулсан байна.

3.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн ч зарим гэрээний биелэлт хангалтгүй байна

3.2.1. Ихэнх арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон ч бий болгосон зарим хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2021, 2022 оны эхний хагас жилийн хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулгаж, гэрээний хэрэгжилт, бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон эсэхийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих мод, бутны хамгаалалтын ажилд шаардагдах хашааны шонг нийлүүлж дуусаагүй байхад санхүүжилт болох 18.0 сая төгрөгийг бүрэн олгосон байна.
- Тус аймагт 2021, 2022 онд байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар бий болгосон нийт 153.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна. Тухайлбал:


- ✓ ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн хийж гүйцэтгэсэн “Өвөрхангай аймагт байгалийн ашигт ургамлын тархац” 15.0 сая төгрөгийн өртөгтэй судалгааны товхимол /2021 он/,
- ✓ Арвайхээр сумын тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын нийлүүлсэн 18.0 сая төгрөгийн 3600 ширхэг хашааны шон /2021 он/,
- ✓ Иргэн Д.Шийлэгбундын нийлүүлсэн 8.9 сая төгрөгийн үнэтэй 3 ширхэг хөрсөнд үл нэвчих ариун цэврийн байгууламж, хогийн сав /2021 он/,
- ✓ Согоот хайрханы буян ХХК-ийн нийлүүлсэн 35.6 сая төгрөгийн хоёрдогч түүхий эд нягтруулах төхөөрөмж /2021 он/,
- ✓ Их-өшгөг ХХК-ийн нийлүүлсэн 75.5 сая төгрөгийн хашааны материал тор /2022 он/

3.2.2. Ойжуулалтын ажил үр дүнтэй байгаа ч зарим арга хэмжээний гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй байна

Байгаль хамгаалах нөхөн сэргээх 12 арга хэмжээг 2021 онд 180.4 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх гэрээ байгуулснаас “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих мод, бутны хамгаалалтын ажилд шаардагдах хашааны шон нийлүүлэх 18.0 сая төгрөг, хоёрдогч түүхий эд нягтруулах төхөөрөмж нийлүүлэх 35.6 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгч нар гэрээний үүргийг хугацаанд нь биелүүлээгүй байна.

Харин 2022 онд 363.1 сая төгрөгийн 9 арга хэмжээг гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан ба үүнээс зөөврийн эко ариун цэврийн байгууламж нийлүүлэх 38.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгч гэрээний биелэлтийг хугацаанд нь хангаагүй байна.

Нийт 91.6 сая төгрөгийн дүн бүхий ажлын 3 гэрээний хэрэгжилт төлөвлөсөн хугацаанаас 42-190 хоногоор хэтэрсэн байна.



Сум дундын ойн ангийн 2021 оны ажлын тайлангаас үзэхэд Бат-Өлзий сумын нутаг дахь улсын тусгай хамгаалалттай Хойд агуйтын Сүвээт хэмээх газарт “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд ойгоос мод бэлтгэсэн 8 аж ахуйн нэгж нь 8 га талбайд хувийн хөрөнгөөр, Их сумт хайрхан, Өгөөмөр шунхлай ХХК-иуд нь 20 га талбайд улсын төсвийн хөрөнгөөр ойжуулалтын ажил хийжээ.

Мөн тус сумын аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд нийлж ЕБС-ийн арын зам дагуу, цэцэрлэгт хүрээлэнд гоёл чимэглэлийн 7789 мод тарьсан байна.

Аудитын явцад ойжуулалтын ажлыг газар дээр нь очиж үзэхэд улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн 20 га талбайг бүрэн хашаажуулсан, ойжуулалтын ургалт 90 хувьтай байна.

Зураг 1 / Бат-Өлзий суманд хийгдсэн ойжуулалт, хашаажуулалт /




“ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөний хүрээнд байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 2022 онд мод үржүүлгийн газруудын чадавхыг бэхжүүлэх, тарьц суулгац бэлтгэхээр сонгон шалгаруулалтад шалгарсан аж ахуйн нэгжүүдийн ажлын үр дүнг аудитын явцад газар дээр нь очиж үзэхэд Сум дундын ойн анги, Өгөөмөр шунхлай ХХК, Их сумт хайрхан ХХК, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ зэрэг мод үржүүлгийн газрууд нь ашиглагдахгүй байсан талбайгаа бүрэн ашиглаж, 15-20 нэр төрлийн модыг үрээр нь тарьж ургуулан, үр бордоо үйлдвэрлэж байна.

Зураг 2 / Сум дундын ойн анги, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын хүлэмжийн үрсэлгээ /



3.2.3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр зарцуулаагүй байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төсөвт Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль хамгаалах нөхөн



сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах” журмын 3-т тусгагдаагүй зарим арга хэмжээг төлөвлөсний улмаас төсвийг зориулалт бусаар зарцуулсан тохиолдлууд гарсан байна.

Тухайлбал: 2021 онд аялал жуулчлалын чиглэлийн 3 арга хэмжээнд 47.0 сая, тоног төхөөрөмж худалдан авахад 5.5 сая, ажлын дүрэмт хувцсанд 4.8 сая, бусад арга хэмжээнд 3.8 сая, нийт 61.1 сая төгрөг, 2022 оны эхний хагас жилийн байдлаар модны тарьц суулгац худалдан авах зардалд 60.0 сая төгрөг, дээрх онуудад нийт 121.1 сая төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 15.6 хувийг зориулалт бусаар зарцуулжээ.

4. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна

4.1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтэд тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна

4.1.1. Арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, баталгаажуулсан байна

Байгалийг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажилд тавих захиалагчийн хяналтыг аймгийн БОАЖГ-ын холбогдох мэргэжилтнүүд, Сум дундын ойн анги хариуцан хэрэгжүүлжээ. Аудитын хамрах хүрээнд ойн зурвас байгуулах, булаг, шандын эхийг хаших, зэрлэг ан амьтдад чиглэсэн биотехникийн арга хэмжээ, ойн хортон шавжтай тэмцэх зэрэг хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийн явц, хүлээж авсан актыг тухай бүрд нь баталгаажуулж ажилласан байна.

4.1.2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалтад тавих ТЕЗ-ийн дотоод хяналт үр нөлөө багатай байна

Аймгийн Засаг даргын захиалгаар хэрэгжүүлсэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналтын нэгжээр шалгалт хийгдээгүй байна. Аудитын явцад тодруулснаар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт болон хөндлөнгийн хяналт хийгдэж байгаагүй тухай холбогдох мэргэжилтнүүд мэдээлсэн.

4.2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд харьяа дээд шатны байгууллагаас хийгдэх хяналтыг эрчимжүүлэх шаардлагатай байна

4.2.1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төрийн байгууллагуудаас тавих хяналтыг хэрэгжүүлж байна

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтэд БОАЖГ-ын мэргэжилтнүүд анхан шатны хяналтыг хэрэгжүүлэн ажилладаг. Тус арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлын гүйцэтгэлийг хүлээн авч баталгаажуулахад мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөллийг байлцуулдаг байна. Аудитын хамрах 2020, 2021 онуудад Мэргэжлийн хяналтын газраас уул уурхайн нөхөн сэргээлт, хууль бус алт олборлолт, ойн хортон шавжтай тэмцэх арга хэмжээнд болон иргэдээс ирсэн гомдлын дагуу хийгдсэн хяналт шалгалт зонхилж байна. Харин БОАЖЯ, бусад төрийн байгууллагаас байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний гүйцэтгэлд хяналт шалгалт хийгдээгүй байна.

4.2.2. Арга хэмжээний зарцуулалтад тавих төрийн байгууллагуудын хяналтыг сайжруулах шаардлагатай байна

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 2020 оны арга хэмжээнд зарцуулагдсан хөрөнгийн зарцуулалтад Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газраас гүйцэтгэлийн аудитыг аймгийн ИТХ-ын захиалгаар 2021 онд гүйцэтгэж байжээ. Өмнөх онуудад уг арга хэмжээний зарцуулалтад төрийн байгууллагуудаас хяналт шалгалт хийгдэж байгаагүй байна.



Тайлан баталгаажуулах тушаал:



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2022 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 1/20

Арвайхээр

Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүрэг"-ийн 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгийн зарцуулалтын үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ӨВА-2022/31-07-ШТА-ГА/-г баталгаажуулсугай.
2. "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгийн зарцуулалтын үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газар /Ц.Хишигжаргал/, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /О.Пүрэвдорж/, аймгийн Засаг дарга /А.Ишдорж/, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Г.Баясгалан / нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2023 оны 03 дугаар сарын 15-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /О.Пүрэвдорж/, аймгийн Засаг дарга /А.Ишдорж /, аймгийн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Г.Баясгалан / нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Аудитын менежер /Д.Гансүх/, ахлах аудитор /С.Шийлэгмаа/ нарт даалгасугай.
5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /С.Шийлэгмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal



Холбогдох байгууллагын санал:


ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР


Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас: (976) 7032 3260,
Цахим шуудан: Uvurkhangainature@gmail.com
Цахим хуудас: www.Uvurkhangai-baigal-orchin.com

Хол. 09.50 № 126
танай 2022-09-28-ны № 487 -Т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх
арга хэмжээний хөрөнгийн зарцуулалтын үр дүнд
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа. Холбогдох санал байхгүй болно.

ДАРГА  Г.БАЯСГАЛАН

D: My Doc, A5 Alban bichig /BOAJG/

622205222



ДҮГНЭЛТ

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

- 1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж байна**
 - 1.1. Аймаг хөгжүүлэх 5-н жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлж байна
 - 1.2. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэж ажилласан байна
- 2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хууль тогтоомжид заасны дагуу төлөвлөж хуваарилаагүй байна**
 - 2.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос батлагдсан төлөвлөгөөний хүрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуульд заасан хувь хэмжээгээр зардал баталж байгаа боловч төлөвлөгөөнөөс давсан орлогоос хөрөнгө хуваарилахгүй байна
 - 2.2. Аймгийн Засаг дарга нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг ИТХ-аар хэлэлцүүлж батлуулахгүй байна
- 3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийн зарим хэсгийг зориулалт бусаар зарцуулсан байна**
 - 3.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна
 - 3.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн ч зарим гэрээний биелэлт хангалтгүй байна
- 4. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна**
 - 4.1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтэд тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна
 - 4.2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд харьяа дээд шатны байгууллагаас хийгдэх хяналтыг сайжируулах шаардлагатай байна

ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн ИТХ-ын дарга О.Пүрэвдорж танаа

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих” гэсэн бүрэн эрхийн дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төсвийг баталж байх.
2. Төсвийг батлахдаа зардлын хэмжээг хуульд заасан хувь хэмжээгээр тооцсон эсэх, хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт нь хууль журамд нийцсэн эсэхийг ИТХ-аар хэлэлцүүлэх, баталсан төсвийн хэрэгжилт, үр дүнд шалгалт хийж холбогдох арга хэмжээг авч байх.

Ингэснээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тавих хяналт сайжирч аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх болно.

Аймгийн Засаг дарга А.Ишдорж, БОАЖГ-ын дарга О.Баясгалан нарт



Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож төлөвлөх
2. Тухайн онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх ажил, хүрэх үр дүнг нарийвчлан тусгаж байх
3. МУЗГ-ын 2022 оны 02 тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлд заасан арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөх, сум, орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэх
4. Төсвийн төслийг тухайн онд хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтын хамт ИТХ-аар хэлэлцүүлж батлуулж байх
5. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох байгууллагаар хангуулж ажиллах
6. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлж хэвших

Ингэснээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын тухайн жилийн зорилтод түвшин хангагдаж, үр дүн, үр ашиг нэмэгдэх болно.